



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 01 сарын 20 өдөр

Дугаар 1/20

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Аймгийн Онцгой комиссын хурлын тогтоол, аймгийн Засаг даргын 2019 оны 6 дугаар албан даалгавар, Засгийн газрын 2019 оны 285 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн нөөцөд 2019-2020 оны өвс бэлтгэн нийлүүлэхээр шууд гэрээ байгуулан ажиллаж байгаа Ганхуягийн Мөнхболдод гэрээний дагуу 2.500.000 /Хоёр сая таван зуун мянган/ төгрөгийг олгосугай.

2. Дээрх арга хэмжээнд зарцуулах 2.500.000 /Хоёр сая таван зуун мянган/ төгрөгийг аймгийн өвс, тэжээлийн нөөцийн санхүүжилтээс олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ц.Ганданповрон/ нарт зөвшөөрсүгэй.

3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Т.Жаргалсайхан/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Б. ДҮГЭРЖАВ

